

ТЕЗ-ИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОЙ УЯЛДСАН ҮР ДҮНД СУУРИЛСАН ТӨСВИЙН САНАЛЫН МАЯГТ БӨГЛӨХ ЗААВАР

1 Төсвийн саналын хамрах хүрээ

УИХ-аас баталсан “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх 2024 оны төсвийн төсөл, 2025 ба 2026 оны төсвийн төсөөллийг үр дүнд суурилсан арга зүйг баримтлан энэхүү зааврын дагуу боловсруулна. Уг зааврыг Европын холбооны санхүүжилттэй НҮБХХ-ийн “Монгол Улсад ТХЗ-той уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд боловсруулав.

2. ТЕЗ-ийн Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан үр дүнд суурилсан төсвийн төслийн саналын маягтыг бөглөх заавар

Сонгосон ТЕЗ-үүд нь зарим хөтөлбөрийнхөө 2024 оны төсвийн төслийг үр дүнд суурилсан төсөвлөлтийн арга зүйг ашиглан дараах 7 маягтын дагуу боловсруулж ирүүлнэ.

- 1) **МАЯГТ: А1** - “Хөтөлбөрийн үр дүн, түүний шалгуур үзүүлэлтүүд”
- 2) **МАЯГТ: А2** –“Хөтөлбөрөөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд”
- 3) **МАЯГТ: Б** – “Хөтөлбөрөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлын төсвийн тооцоолол”
- 4) **МАЯГТ: ТЕЗ-Н** –“Хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гол шалгуур үзүүлэлт, үйл ажиллагааны төсөв, харьяалах нэгжээр”
- 5) **МАЯГТ: ТЕЗ-Х** –“ТЕЗ-ийн үр дүнд суурилсан хөтөлбөрт төсвийн саналын нэгтгэл”
- 6) **МАЯГТ: ТЕЗ-ЭЗА** – “ТЕЗ-ийн үр дүнд суурилсан 2024 оны төсвийн төсөл, эдийн засгийн дэлгэрэнгүй ангиллаар”
- 7) **МАЯГТ: ТЕЗ-Х1** – “ТЕЗ-ийн 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлтүүд”

Дээрх маягтуудыг бөглөхдөө дараах зааврыг баримтална:

1. **МАЯГТ: А1. “Хөтөлбөрийн үр дүн, түүний шалгуур үзүүлэлтүүд”-ийг боловсруулах заавар**

Төсвийн тухай хуулийн 33.2.5-д заасны дагуу ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт нь Монгол Улсын 2024 оны төсвийн тухайн хуулийн нэгдүгээр хавсралт болж батлагдана. Энэ маягтыг дараах байдлаар бөглөнө.

“Бодлогын үндэслэл” баганад ХБТТУТ хуулийн 4.1.6, 4.1.8, 4.1.9-д заасан баримт бичиг буюу МУХТЖҮЧ, ЗГҮАХ, ЗГҮАХХАХТ болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний холбогдох заалтын дугаарыг бичнэ.

“Холбогдох ТХЗ” баганад ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх буй тухайн хөтөлбөрийн үр дүнг тодорхойлсны дараа Тогтвортой Хөгжлийн Зорилго (ТХЗ)-ын холбогдох зорилтын дугаарыг бичнэ.

“Хөтөлбөрийн үр дүн” баганад “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан ТЕЗ-ийн эрхлэх үндсэн асуудлын хүрээний холбогдох хөтөлбөрийн үр дүнг хуулж тавина. Хэрэв тухайн хөтөлбөрийн үр дүн “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд тусгагдаагүй бол тухайн хөтөлбөрийг хариуцсан бодлогын мэргэжилтэн нь Эдийн засаг хөгжлийн сайдын 2022 оны 12 сарын 28-ны өдөр А/167 тоот тушаалаар батлагдсан үр дүнд суурилсан “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу хөтөлбөрийн үр дүнг тодорхойлж маягтад тусгана.

“Шалгуур үзүүлэлт” баганад “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан холбогдох хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт, түүний суурь болон зорилтот түвшнийг хуулж тавина. Хэрэв “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд тухайн хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт тусгагдаагүй бол хөтөлбөрийг хариуцсан бодлогын мэргэжилтэн нь Эдийн засаг хөгжлийн сайдын 2022 оны 12 сарын 28-ны өдөр А/167 тоот тушаалаар батлагдсан үр дүнд суурилсан “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу боловсруулан хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн суурь ба зорилтот түвшнийг батлагдсан төсвийн хязгаарт багтаан тооцож, тодорхойлно.

Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүдийн зорилтот түвшнийг тодорхойлохдоо дараах зарчмыг баримтална:

- Монгол Улсын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд үндэслэх;
- Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.4-т заасан жилийн төсвийн хязгаарт нийцсэн, хэрэгжихүйц байх;
- Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшнийг тодорхойлохдоо харьяа доод шатны байгууллагаас санал авч, зөвшилцөх;
- Нөхцөл байдлын дүн шинжилгээнд үндэслэсэн байх;
- Өнгөрсөн 3 жилийн батлагдсан төсөв, төсөв зарцуулалтын гүйцэтгэлийн дунджийг харгалзах.

2. МАЯГТ: А2. “Хөтөлбөрөөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт”-үүд боловсруулах заавар

Хөтөлбөрийн үр дүнд хүрэхийн тулд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, тэдгээрийн гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлтийн суурь болон зорилтот түвшнийг МАЯГТ А2-ын дагуу боловсруулна.

“Үйл ажиллагааны нэр” баганад хөтөлбөрийн үр дүнг хангах стратеги, арга замын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний багцыг тодорхойлж бичнэ. Үйл ажиллагааг дараах дарааллын дагуу тодорхойлно:

- 1) Хөтөлбөрийн хүрээнд өнгөрсөн жилүүдэд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, тэдгээрийн зарлагад шинжилгээ хийнэ;
- 2) Шаардлагатай бол хөтөлбөрийн үр дүнг хангах зорилгоор хэрэгжүүлэх үйл ажиллагааг дахин тодорхойлох. Монгол Улсын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад хийсэн нөхцөл байдлын шинжилгээгээр тодорхойлсон хөтөлбөрийн үр дүнд хүрэхийн тулд одоо хэрэгжүүлдэг үйл ажиллагааг өөрчлөх, зогсоох эсхүл шинэ үйл ажиллагаа

нэмэх санал гаргаж болно. Үйл ажиллагаа нь байгууллагын эрхлэх асуудлын хүрээг бүрэн хамарсан байх шаардлагатай хэдий ч хэт олон үйл ажиллагаа тодорхойлохоос зайлсхийнэ;

- 3) Үйл ажиллагааг тодорхойлсны дараа зардлын ангилалтай нийцэж буй эсэхийг нягтална. Хэрэв өмнө хэрэгжүүлж ирсэн үйл ажиллагааг өөрчлөх, зогсоох, нэгтгэх, эсхүл шинэ үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр тодорхойлсон бол холбогдох тооцооллыг доод шатны төсвийн захирагчдаас авч нэгтгэнэ.

“Үйл ажиллагааны гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт” баганад тухайн төсвийн жилдээ хэмжиж болохуйц үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанарын болон тоон шалгуур үзүүлэлтийг тусгана. Эдгээр шалгуур үзүүлэлт нь хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшнийг хангаж буй эсэхийг нягтална. Ингэхдээ үйл ажиллагаануудыг 100 хувь хэрэгжүүлэхэд хөтөлбөрийн үр дүнгийн зорилтот түвшин бүрэн хангагдах эсэхийг нягтлах замаар логик уялдаа холбоог шалгана.

“Төсвийн төсөл” хэсэг нь **“МАЯГТ: Б”**-ийн тооцооллоос автоматаар бодогдож бөглөгдөнө.

3. МАЯГТ: Б. “Хөтөлбөрөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлын төсвийн тооцоолол” боловсруулах заавар

ТЕЗ-ийн хөтөлбөрийн үр дүн, үйл ажиллагааны зорилтот түвшинд суурилан хөтөлбөрийн төсвийн тооцоог доороос дээш буюу арга хэмжээний төсвийг нэгтгэн үйл ажиллагааны төсөв, үйл ажиллагааны төсвийг нэгтгэн хөтөлбөрийн төсөв, хөтөлбөрийн төсвийг нэгтгэн ТЕЗ-ийн төсвийн төслийг тус тус тооцно.

Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нийт төсвийн тооцооллыг **МАЯГТ: Б**-ын дагуу боловсруулна.

“Үйл ажиллагааны нэр” баганад **МАЯГТ: А2**-т тусгасан “Үйл ажиллагааны нэр” баганаас хуулж оруулна.

“Зориулалт, арга хэмжээний ангиллын код” баганад **МАЯГТ: А2**-т тодорхойлсон үйл ажиллагааны хамаарах “зориулалт, арга хэмжээ”-ний тохирох код, нэрийг сонгож оруулна. (Сангийн сайдын “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 2015 оны 7 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт)

“Арга хэмжээний нэр” баганад үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээ, төслийг тодорхойлон бичнэ.

“г,д,е,ж” багануудад Тухайн арга хэмжээний хэмжих нэгж, нэгжийн өртөг болон тоо хэмжээ, нийт зардлыг тооцно.

“з,и,к,л” багануудад арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардагдах урсгал болон хөрөнгийн зардлын хэмжээг эх үүсвэрээр задлан оруулна.

“м,н” багануудад арга хэмжээ бүрээр тохирох зардлын ангиллын код, нэрийг бичнэ. Ингэхдээ Сангийн сайдын “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 2015 оны 7 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан эдийн засгийн ангиллын код, нэрээс сонгоно.

Хөтөлбөрийн үйл ажиллагаа, арга хэмжээний зардлыг нэгтгэн хөтөлбөрийн нийт төсвийг тооцно.

Хэрэв үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд олон ажлууд хийх бол хийх ажлуудын төсвийг **Ажлын хүснэгт-1**-ыг ашиглан тооцож болно. Харин үйл ажиллагааны хүрээнд шинээр арга хэмжээ хэрэгжүүлэх тохиолдолд зардлыг нь тооцоход шаардлагатай нэгжийн өртгийг **Ажлын хүснэгт 2** жишээг загвар болгон ашиглаж болно.

4. МАЯГТ: ТЕЗ-Н. “Хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гол шалгуур үзүүлэлт, үйл ажиллагааны төсөв, нэгжээр” боловсруулах заавар

Хөтөлбөрийн үр дүн, түүний шалгуур үзүүлэлтүүдээс үр дүнд хамгийн их нөлөө үзүүлэх зөвхөн нэг шалгуур үзүүлэлтийг гол шалгуур үзүүлэлт (KPI) болгон сонгоно. Хөтөлбөрийн үр дүнгийн гол шалгуур үзүүлэлтэд аймаг, нийслэл, дүүрэг дэх нэгж байгууллагууд болон харьяа байгууллагуудын оруулах хувь нэмрийг зөвшилцөж, нэгж байгууллага бүрээр оруулна.

“б” баганад хөтөлбөрийн үр дүнг хэрэгжүүлэх харьяа аймаг, нийслэл, дүүрэг дэх газар, хэлтэс болон харьяа байгууллагын нэрийг бичнэ.

“в-г” баганад хөтөлбөрийн үр дүнгийн нэг гол шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшин, тухайн нэгжид хуваарилах хөтөлбөрийн төсвийн хэмжээг тус тус бичнэ.

“д-...N” баганад хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр **МАЯГТ: А2** болон **МАЯГТ: Б**-д тодорхойлсон үйл ажиллагаа бүрээр төсвийг нэгж байгууллагаар задлан оруулна.

5. МАЯГТ: ТЕЗ-Х. ТЕЗ-ийн үр дүнд суурилсан хөтөлбөрт төсвийн саналын нэгтгэл боловсруулах заавар

ТЕЗ-ийн хөтөлбөр тус бүрийн 2024 оны төсвийн төслийг **МАЯГТ: Б**. “Хөтөлбөрөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлын төсвийн тооцоолол”-оос авч урсгал болон хөрөнгийн зардлаар ангилан 2024 оны төсөв, 2025, 2026 оны төсвийн төсөөллөөр буюу дунд хугацаагаар хөтөлбөрийн төсвийн төслийг харуулна.

“Хөтөлбөрийн нэр” болон “Код” баганад Сангийн сайдын “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 2015 оны 7 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаас тухайн ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний хөтөлбөрийн нэр болон кодыг сонгож оруулна.

“Төсвийн төсөл” баганад хөтөлбөрийн 2024 оны төсвийн төслийг урсгал болон хөрөнгийн зардлаар ангилан оруулна.

“Төсөөлөл” баганад хөтөлбөрийн 2025 болон 2026 оны төсвийн төсөөллийг урсгал болон хөрөнгийн зардлаар ангилан харуулна.

ТЕЗ-ийн хэрэгжүүлэх нийт хөтөлбөрүүдийн төсвийн төслийг нэгтгэн ТЕЗ-ийн нийт төсвийг тооцож оруулна.

6. МАЯГТ: ТЕЗ-ЭЗА. “ТЕЗ-ийн үр дүнд суурилсан 2024 оны төсвийн санал, эдийн засгийн дэлгэрэнгүй ангиллаар” боловсруулах заавар

Сонгосон ТЕЗ нь үр дүнд суурилсан төсөвлөлтийн арга зүйг ашиглан төсөвлөсөн хөтөлбөр тус бүрийн төсөв болон нийт хөтөлбөрийн төсвийн төслийг эдийн засгийн дэлгэрэнгүй ангиллаар задлан оруулна.

7. МАЯГТ: ТЕЗ-Х1. “ТЕЗ-ийн 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлтүүд” боловсруулах заавар

МАЯГТ: А1-д тодорхойлсон хөтөлбөрийн бүх үр дүн, тэдгээрийн бүх шалгуур үзүүлэлтүүдийн суурь түвшин, 2024 оны зорилтот түвшнийг хэмжих нэгжийн хамт оруулна. Энэ маягтын хамгийн сүүлийн баганад шалгуур үзүүлэлтийг гаргах мэдээллийн эх сурвалжийг тодорхойлж бичнэ.

--oOo--